



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот.

Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж,
үйлчилгээний чанар, хүртээмжийг
сайжруулах тухай

Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээг сайжруулах жил” болгон зарлаж, Эрүүл мэндийн яамнаас “Инээмсэглэл-“Эерэг хандлага” уриаг дэвшүүлэн, Нийслэлийн Засаг даргаас “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээг дэмжих жил” тус тус болгосонтой холбогдуулан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний тэгш байдлыг хангах, эх хүүхдийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, цаг ашиглалт, ажлын хариуцлага, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор нийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтануудад ДААЛГАХ нь:

1. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн багийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган, дотоод ардчиллыг бүрдүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын идэвх санаачилгыг дэмжин, шинэ санаачилга, тэргүүн туршлагыг нэвтрүүлэн ажиллах,

1.2 Ажлын цаг ашиглалт, сахилга, хариуцлагыг сайжруулахад онцгойлон анхаарах, ажиллагсадын үдийн цайнд орох цагийг зөрүүлэх байдлаар ажлын цагт зохицуулалт хийж, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах,

1.3 Эрүүл мэндийн анхан шатны болон яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, хүлээгдэл чирэгдэлгүй үйлчлэх зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч ажиллах,

1.4 Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд анхаарч, “Сэтгэлд нийцсэн 8 үйлчилгээний удирдамж”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх,

1.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх,

2. Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

2.1 Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн хүн амын бүртгэл судалгаа, ялангуяа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг шинэчлэн гаргаж, шилжилт хөдөлгөөнийг хагас жил тутамд хийж, эрсдэлт бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд гэр бүл төлөвлөлт, эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг өргөжүүлэн ажиллах,

2.2 Жирэмсэн эмэгтэйд харьяалал харгалзахгүй тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэхийг онцгойлон анхаарах,

2.3 Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 338 дугаар тушаалаар батлагдсан “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-ын хэрэгжилтийг хангах, эмч, мэргэжилтнүүдийг сургах, чадавхжуулах талаар олон талт ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнд үнэлгээ, дүгнэлт хийж ажиллах,

2.4 0-5 насны хүүхдийн хяналтын чанар, хүртээмж, зөвлөгөө өгөх ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч, холбогдох стандарт, дүрэм, журамд заасны дагуу 0-5 насны хүүхдийн хяналт, үзлэгийг хийж буй байдалд чанарын үнэлгээг хийж, эмч, сувилагч нарын дунд ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулж, мэдлэг, чадварыг үнэлэн, хэрэгцээнд суурилсан сургалтаар ханган, ажлын үр дүнтэй уялдуулан урамшуулал, хариуцлагыг тооцон ажиллах,

2.5 Иргэдийн дунд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг өрнүүлж, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх.

3. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгах нь:

3.1 Энэхүү албан даалгаврыг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

3.2 Албан даалгаврын хэрэгжилтийн тайланг 2019 оны 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-нд тус тус авч нэгтгэн дүгнэж, Гүйцэтгэлийн гэрээний биелэлтийн хагас, бүтэн жилийн үнэлгээнд тусган, үнэлгээний дүнгийн тайлангийн хамт Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлэх.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР